Бөөргийн ам алтны ордын ашиглалтын системийг сонгохдоо ордын уул геологийн нөхцөл, элсний биетийн хэлбэр ба байршил, хучаас хөрсний зузаан, өмнөх жилүүдэд ашиглаж байсан хөлдүү чулуулгийг Бульдозероор сийрэгжүүлэн экскаватороор автосамосвалд тээвэр хийх, ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ-тодотгол-II ийг боловсруулав.

*Хүснэгт 8 Ил уурхайн ашиглалтын технологийн схем*

| Технологи | Үндсэн ажил | Технологийн процессууд |
|---|---|---|
| **Авто тээвэртэй ашиглалтын технологи** | 1. Хөрс хуулалт | 1.1.Бульдозероор сийрэгжүүлэх<br>1.2. Ухаж ачих<br>1.3. Тээвэрлэх<br>1.4. Овоолох |
| | 2.Элс олборлолт | 2.1. Ухаж ачих<br>2.2. Тээвэрлэх<br>2.3. Овоолох |

Хөлдүү чулуулагтай шороон ордод гадаргын хөлдүү дээд үеийг сэндийлэхэд бульдозероор агрегат буюу соёогоор сийрэгжүүлэх арга нь нийлээд үр дүнтэй байна.




*Зураг 11 Бульдозерын агрегатаар сийрэгжүүлэх схем*




Зураг 121 – Буцах-давших; 2 – Дагуу тойрох; 3 - Спираль; 4 – Хөндлөн дагуу

*Зураг 13. Бульдозерын агрегатаар сийрэгжүүлэх орлын чиглэлүүд*

### 1.3.4 Ил уурхайн технологийн процесс

Тууз хэлбэрийн багахан зузаантай хэвтээ байрлал бүхий дөрөвдөгчийн Бөөргийн ам алтны шороон орд ордын ашиглалтын системийг сонгохдоо ордын уул геологийн нөхцөл, элсний биетийн хэлбэр ба байршил, хучаас хөрсний зузаан зэрэгт үндэслэн ордыг ил уурхайн аргаар, авто тээвэртэй гадаад болон дотоод овоолготой, ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ- тодотгол II ийг боловсруулав.




*Зураг 14 Ил уурхайн технологийн процесс*

### 1.3.5 Ил уурхайн уулын ажлын механикжуулалд

Бөөргийн голын уулын ажлын календарьчилсан төлөвлөлтийг ордын уул геологийн нөхцөл, элс угаан баяжуулах хэсгийн хүчин чадал болон олборлолтод ажиллах техникүүдийн хүчин чадалд тулгуурлан боловсруулав. Ил уурхай ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 1,795.03 мян.$м^3$ уулын цул үүнээс 256.52 мян.$м^3$ элс олборлож, 1,538.51 мян.$м^3$ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 6.10 $м^3/м^3$ байна.

Тус ордыг түрээсийн техниктэй гэрээ байгуулан олборлох бөгөөд орд дээр ажиллах ажиллах үндсэн техникийн тоо авч үзвэл:

*Хүснэгт 9. Ил уурхайд ажиллах үндсэн техникийн тоо*

| Д/д | Тоног Төхөөрөмж | Марк | Хэмжих нэгж | Утга | Тоо ширхэг | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | I-р жилд | II-р жилд |
| 1 | Экскаватор | Doosan-530 DX | м3 | 3.2 | 2 | 1 |
| 2 | Утгуурт ачигч | XZ656L | м3 | 3 | 1 | 1 |
| 3 | Бульдозер | D9 | м3 | 13 | 1 | 1 |
| 4 | Авто самосвал | 336 | тн | 25 | 4 | 4 |
| 5 | Гэрэлт цамхаг | Terex RL4 | кВт | 6 | 2 | 2 |

*Хүснэгт 10. D9 маркийн бульдозерын техникийн үзүүлэлт*

| Д/д | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Утга | |
|---|---|---|---|---|
| | | | Хөрс | |
| 1 | Бульдозерийн марк | | CAT D9 |  |
| 2 | Хусуурын төрөл | - | - | |
| 3 | Хөдөлгүүрийн чадал | кВт | 302 | |
| 4 | Масс | тн | 48.5 | |
| 5 | Хусуурын хамах чадвар | м3 | | |
| 6 | Хусуурын урт | м | 4.31 | |
| 7 | Хусуурын өндөр | м | 1.93 | |
| 8 | Ухах гүн | м | 0.606 | |
| 9 | Хөдөлгөөний хурд | км/цаг | 8.4 | |

Газрын хөлдүү дээд үеийг сэндийлэхэд CATD9 Бульдозерын сийрэгжүүлэгч агрегат маш өндөр бүтээл гаргах боломжтой бөгөөд орлын урт 30-50 м хөлдүү чулуулаг сийрэгжүүлэхэд 116 $м^3$/цаг бүтээлтэй байх тооцоо гарч байгаа бөгөөд ашиглалтын жилд CATD9 бульдозероор 1 ш байхад бүтээлийн хувь хүрэлцээтэй байна.

**Хөрс хуулалтад ажиллах экскаваторын төхөөрөмжийн тооцоо**

*Хүснэгт 11. Хөрс хуулалтад ажиллах экскаваторын техникийн үзүүлэлт*

| Д/д | Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Техникийн үзүүлэлт | Техникийн зураг |
|---|---|---|---|---|
| 1 | Экскаваторын марк | - | Doosan-530 DX |   |
| 2 | Хутгуурын багтаамж | м3 | 3.2 | |
| 3 | Хутгалтын түвшин дэх хамгийн их радиус | м | 11.6 | |
| 4 | Утгалтын хамгийн их гүн | м | 7.1 | |
| 5 | Утгалтын хамгийн их өндөр | м | 10.9 | |
| 6 | Ачилтийн хамгийн их өндөр | м | 7.5 | |
| 7 | Арын эргэлтийн радиус | м | 3.8 | |
| 8 | Хөдөлгүүрийн чадал | кВт | 232 | |
| 9 | Явах хурд | км/цаг | 4.7 | |
| 10 | Масс | тн | 53.4 | |
| 11 | Түлшний савны багтаамж | л | 610 | |
| 12 | Явах ангийн өргөн | м | 3.6 | |
| 13 | Явах ангийн урт | м | 5.4 | |
| 14 | Их өиеийн өргөн | м | 2.9 | |
| 15 | Их биеийн Өндөр | м | 3.3 | |

Техникийн бүтээлийн тооцоогоор ил уурхайн ашиглалтын эхний жилд уулын цулд ажилд Doosan-530 DX маркийн 3.2 м3 утгуурын багтаамжтай экскаватор 2 ш, шаардлагатай байна. ашиглалтын хоёр дох жилд уулын цулд ажилд Doosan-530 DX маркийн 3.2 м3 утгуурын багтаамжтай экскаватор 1 ш тус тус шаардлагатай байна.

## 1.4 Баяжуулалтын технологи

### 1.4.1 Элс баяжуулах технологийн тооцоо

Элс угаан баяжуулах хэсэг нь уурхайн төлөвлөлтийн дагуу нийт 256,52 $мян.м^3$ элс хоёр жилийн хугацаанд олборлох бөгөөд эхний жилд дунджаар 556,79 $мг/м^3$ агуулгатай 168,74 мян м3 элс, хоёр дахь жилд дунджаар 527,52 $мг/м^3$ агуулгатай 87,77 мян $м^3$ элс, ашиглалтын нийт хугацаанд дунджаар 546,78 $мг/м^3$ агуулгатай 256,52 мян $м^3$ элс баяжуулах юм. Элс угаалга баяжуулалтын ажиллагаа улирлын чанартай явагдана.

Баяжуулах хэсгийн хүчин чадал:

- Сарын хүчин чадал 24480.0 $мян.м^3$
- Хоногийн хүчин чадал 816.0$м^3$
- Цагийн хүчин чадал 40.0 $м^3$/цаг

Баяжуулах технологи:

- Гравитаци /Скруббер-бутар, шлюз, баяжуулах ширээ, гар тэвш)

### 1.4.2 Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө

Баяжуулах хэсэг нь 546,78 мг/м$^3$ алт агуулагч 256.52 мян.м$^3$ элсийг гравитацийн аргаар 90%-ийн металл авалттай баяжуулж төслийн нийт 3 жилийн хугацаанд 126.23 кг шлихийн алт, химийн цэврээр 112.85 кг алт гаргана.

*Хүснэгт 12. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо*

| № | Үзүүлэлтүүд | Тоон утга | | |
|---|---|---|---|---|
| Ил уурхайгаас | | | | |
| Хугацаа | | 1-р жил | 2-р жил | Нийт |
| 1 | Угаан баяжуулах элс,мян.м$^3$ | 168,74 | 87,77 | 256,52 |
| 2 | Элсэн дэх алтны агуулга, мг/м$^3$ | 556,79 | 527,52 | 546,78 |
| 3 | Элсэн дэх алт, кг | 93.953 | 46.300 | 140.25 |
| Угаан баяжуулах үйлдвэр | | | | |
| 4 | Угаан баяжуулах элс | 168,74 | 87,77 | 256,52 |
| 5 | Элсэн дэх алтны агуулга | 556,79 | 527,52 | 546,78 |
| 7 | Алт авалт,% | 90.0 | 90.0 | |
| 8 | Алтны хэмжээ /шлихээр/, кг | 84.560 | 41.670 | 126.23 |
| 10 | Хаягдал дахь алт авалт,% | 10 | 10 | |
| 11 | Хаягдал дахь алтны хэмжээ /шлихээр/, кг | 9.39 | 4.63 | 14.02 |

***Хаягдал гаргалтын тооцоо:*** Баяжуулах хэсгийн хаягдал нь төслийн нийт хугацаанд боловсруулалтаас гарч буй 63.693 мян.м$^3$ галь, 191.926 мян.м$^3$ Эйфел байна. Доорх хүснэгтэд төслийн нийт хугацаанд хаягдах хаягдлын хэмжээг тодорхойлов.

*Хүснэгт 13. Хаягдал гаргалтын тооцоо*

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | Ашиглалтын жил | | Нийт |
|---|---|---|---|---|
| | | 1 жил | 2 жил | |
| Элсний хэмжээ | мян.м3 | 168.745 | 87.773 | 256.518 |
| Галийн хэмжээ | мян.м3 | 41.899 | 21.794 | 63.693 |
| Эфелийн хэмжээ | мян.м3 | 126.25 | 65.67 | 191.926 |
| Нийт хаягдал | мян.м3 | 168.154 | 87.466 | 255.620 |

Алт агуулсан элс баяжуулалтаас гарч буй хаягдал нь +20 мм ширхэглэлтэй галь, -20 мм ширхэглэлтэй Эйфел байна. Уг ордын элсийг баяжуулахад ямар нэгэн химийн хортой бодис ашиглахгүй тул гарч буй шингэн хаягдлыг тунаах нуурын тусламжтай тунгааж цэвэршүүлэн, үйлдвэрлэлийн процесст эргэлтийн усны журмаар эргүүлэн ашиглана. Ордын элсийг усаар задлахад гарах ш тунах шламын урд хурдан, шаврын агууламж багатай.




*Зураг 15 Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмжийн холболтын схем*




*Зураг 16 Баяжуулах цехийн тоног төхөөрөмжийн холболтын схетийн тайлбар*

*Хүснэгт 14 Элс угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжүүдийн жагсаалт*

| № | Тоног төхөөрөмжийн нэр | Төрөл | Х.н | Тоо, ш | Хөдөлгүүрийн чадал, кВт | Хүчин чадал | Ашиглалтад орсон он | Нийт ашиглалтын хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Угаан баяжуулах төхөөрөмж | ПГШ-60 | $м^3$/цаг | 1 | 22 | 60 | 2018 | 5 |
| 2 | Баяжуулах ширээ | СКО-0.5 | ш | 1 | 0.5 | 0.5 | 2018 | 4 |
| 3 | Эргэлтийн усны насос | ДА 200-36а | ш | 2 | 75 | 320 | 2015 | 7 |
| 4 | Цэвэр усны насос | ЭЦВ-8 | ш | 2 | 15 | 25 | 2015 | 7 |
| 5 | Баяжмал хатаах зуух | | ш | 1 | | | 2018 | 5 |
| 6 | Шигших үлээн ангилах ширээ | | ш | 1 | | | 2018 | 5 |

### 1.4.3 Баяжуулах хэсгийн тоног төхөөрөмж

**Угаан шигших төхөөрөмж**

Угаан шигших төхөөрөмжийг Орос инженерүүд үйлдвэрлэсэн. Тус төхөөрөмж нь усны зарцуулалт бага, угсралт суурилуулалтын ажил хялбар, орчин үеийн металл авалт өндөр дэвшилтэт төхөөрөмж юм.

Хүрдэн шигшүүрээс гадна шлюз нь өөр дээрээ ус цацруулах трубаг суурилуулсан. Шлюз дээрх баяжмалын дагтаршлыг арилгах, алтыг резинэн дэвсгэр дээр суух таатай нөхцөлийг бүрдүүлдэг байна. Скрубберийн шлюз нь 1 тал руу унасан байрлалтай суурилагдана.

*Хүснэгт 15 Сонгосон скруббер бутарын техникийн үзүүлэлт*

| № | Төхөөрөмжийн үзүүлэлт | Х.н | Тоо, ш |
|---|---|---|---|
| 1 | Хүчин чадал | $м^3$/цаг | 60 |
| 2 | Хүлээн авах хамгийн том мөхлөгийн хэмжээ | Мм | 200 |
| 3 | Диаметр | мм | 3200 |
| 4 | Урт | мм | 7000 |
| 5 | Жин | Тн | 15 |
| 6 | Цахилгаан хөдөлгүүрийн чадал | кВт | 22 |
| 7 | Суурилагдах тоо | ш | 1 |



**Баяжуулах ширээний хүчин чадал, техникийн үзүүлэлт**

Баяжуулах ширээний бүтээмж нь тэжээл дэх хүдрийн ширхэглэл, эрдсийн нягтын ялгаа, бүтээгдэхүүнд тавигдах чанарын шаардлага зэргээс хамаардаг. Угаан баяжуулах цех нь нэг баяжуулах ширээтэй байх ба шлюзийн баяжмалыг баяжуулж шлихийн алт гарган авах үүрэгтэй байна.

*Хүснэгт 16 Баяжуулах ширээний техникийн үзүүлэлт*

| № | Төхөөрөмжийн үзүүлэлт | Х.н | Утга |
|---|---|---|---|
| 1 | Баяжуулах ширээний марк | - | 7-s |
| 2 | Хүчин чадал | Тн/өдөр | 30-60 |
| 3 | Ашиглалтын талбай | М2 | 7-6 |
| 4 | Урт | мм | 4.450 |
| 5 | Дамжуулах хэсгийн өргөн | мм | 1.855 |
| 6 | Баяжмал хэсгийн өргөн | М | 1.546 |
| 7 | Тэжээлийн хэмжээ | Мм | 2 |
| 8 | Тэжээлийн нягт | % | 25-30 |
| 9 | Ажиллагааны давтамж | | 45-48 |
| 10 | Ус зарцуулалт | Тн/өдөр | 80-150 |
| 11 | Хөдөлгүүрийн чадал | кВт | 1.1 |
| 12 | Шаардлагатай тоо | ш | 1 |



Баяжуулах ширээний бүтээмж нь тэжээл дэх хүдрийн ширхэглэл, эрдсийн нягтын ялгаа, бүтээгдэхүүнд тавигдах чанарын шаардлага зэргээс хамаардаг. Угаан баяжуулах цех нь нэг баяжуулах ширээтэй байх ба шлюзийн баяжмалыг баяжуулж шлихийн алт гарган авах үүрэгтэй байна. Баяжуулах ширээний бүтээмж нь тэжээл дэх хүдрийн ширхэглэл, эрдсийн нягтын ялгаа, бүтээгдэхүүнд тавигдах чанарын шаардлага зэргээс хамаарна.

*Хүснэгт 17 Усны насосын техникийн үзүүлэлт*

| № | Төхөөрөмжийн үзүүлэлт | Х.н | Тоо, ш |
|---|---|---|---|
| 1 | Марк | $м^3$/цаг | 60 |
| 2 | Хүчин чадал | Мм | 200 |
| 3 | Өргөлт | мм | 3200 |
| 4 | Дугуйн эргэлт | мм | 7000 |
| 5 | Хөдөлгүүрийн чадал | Тн | 15 |
| 6 | Шаардлагатай тоо | кВт | 22 |



*Тайлбар: Оросын Д320-50 маркийн насос нь 320м3/ц, маркийг сонгосон*

***Угаан баяжуулах цехийн усан хангамжийн тоног төхөөрөмж***

Угаан баяжуулах цехийн усан хангамжийн хэсэгт технологийн шаардлагатай ус болон эргэлтийн ус татах насосууд ашиглагдана. Тоног төхөөрөмжийн сонголтыг технологийн ус шламын тооцооны үр дүнд үндэслэн сонгосон.

*Хүснэгт 18 Технологийн ус шахах насосны техникийн үзүүлэлтүүд*

| № | Төхөөрөмжийн үзүүлэлт | Эргэлтийн усны насос | Усан бууны насос |
|---|---|---|---|
| 1 | Марк | Д 200-36а | Д 200-36а |
| 2 | Хүчин чадал | 200 | 200 |
| 3 | Өргөлт | 36 | 36 |
| 4 | Дугуйн эргэлт | 1450 | 1450 |
| 5 | Хөдөлгүүрийн чадал | 21,5 | 21,5 |
| 6 | Шаардлагатай тоо | 1 | 1 |



## 1.5 Дэд бүтэц

<table>
<tr><td>Уурхайн тосгон, барилга байгууламж</td><td>
Төслийн хугацаанд ажилчдын хотхонд хамгийн ихдээ 34 хүн байрлах бөгөөд амрах байр, удирдлагын байр, засварын газар, гал тогоо, агуулах, угаалга, бие засах, шүршүүрийн байрууд байхаар төлөвлөсөн. Ажилчдын байр хүн амьдрахаар тохижуулсан гэр байх бол шүршүүр, угаалга, бие засах газар мөн засаж тохижуулсан 40 тн-ын 2 ширхэг контейнер байна. Удирдлагын байр болон гал тогооны байр нь сэндвичээр барьсан 1 давхар байр байна.
Засварын газар болон харуулын байруудыг сэндвичид хавтангаар байгуулах ба сэлбэг, тос тосолгооны материалын агуулах нь контейнерууд байна. Мөн шатахуун түгээх станцыг байгуулна.
<table>
<tr><th>Д/д</th><th>Барилга, байгууламжийн нэр</th><th>Хэмжих нэгж</th><th>Хэмжээ</th><th>Тайлбар</th></tr>
<tr><td colspan="5">Уурхайн хотхон</td></tr>
<tr><td>1</td><td>Уурхайн удирдлагын байр</td><td>м2</td><td>36</td><td>2 өрөөтэй 1 давхар байр</td></tr>
<tr><td>2</td><td>Ажилчдын сууц</td><td>ш</td><td>19</td><td>Тохижуулсан гэр</td></tr>
<tr><td>3</td><td>Цайны газар, гал тогоо</td><td>м2</td><td>54</td><td>Тохижуулж гэр</td></tr>
<tr><td>4</td><td>Бие засах, халуун ус болон угаалга</td><td>м2</td><td>60</td><td>40 тонны 2 контейнерыг холбон тохижуулна.</td></tr>
<tr><td>5</td><td>Цэвэр ус хадгалах сав</td><td>ш</td><td>1</td><td>20 м$^3$-ийн багтаамжтай сав байна.</td></tr>
<tr><td>6</td><td>Ахуйн бохир хадгалах сав</td><td>м2</td><td>10</td><td>Газар доор 20 м$^3$-ийн багтаамжтай сав байгуулна.</td></tr>
<tr><td>7</td><td>Сагсан бөмбөгийн талбай</td><td>м2</td><td>450</td><td>Ажилчид чөлөөт цагаа өнгөрөөх</td></tr>
<tr><td colspan="5">Ил уурхай</td></tr>
<tr><td>1</td><td>Засварын газар</td><td>м2</td><td>100</td><td>Сэндвичээр 12x8 м хэмжээтэй байр барина.</td></tr>
<tr><td>2</td><td>Шатахуун түгээх газар</td><td>м2</td><td>15</td><td>50 тонны багтаамжтай сав</td></tr>
<tr><td>3</td><td>Сэлбэгийн агуулах</td><td>м2</td><td>15</td><td>20 тонны контейнер</td></tr>
<tr><td>4</td><td>Тос тослох материал агуулах</td><td>м2</td><td>30</td><td>40 тонны контейнер</td></tr>
<tr><td>5</td><td>Харуулын байр</td><td>м2</td><td>27</td><td>9 м2 талбайтай 3ш сэндвичин байр</td></tr>
<tr><td>6</td><td>Уурхайг тойрсон хашаа</td><td>м</td><td>4,521</td><td>1.5 м-ийн өндөртэй торон хашаа</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>Цахилгаан хангамж</td><td>
Ил уурхай, угаан баяжуулах цех болон бусад ашиглалтын туршид цахилгаан эрчим хүч хэрэглэх цахилгаан хэрэглэгчдийн цахилгаан ачаалал, тэдгээрийн цахилгаан эрчим хүчний зарцуулалтыг тооцов. Уурхайн ашиглалтын үед цахилгааны үндсэн гурван хэрэглэгч байна. Үүнд:
<ol><li>Угаан баяжуулах</li><li>Засварын газар</li><li>Уурхайн хотхон</li><li>ШТС</li></ol>
Дээрх чадлыг хангах ДС-200 дизель станц 1 ш суурилуулах шаардлагатай. Уурхайн найдвартай ажиллагааг хангах зорилгоор дахин нэг дизель станц нөөцөд байлгах нь зүйтэй юм.
</td></tr>
<tr><td>Усан хангамж</td><td>Уурхайн унд-ахуйн буюу хотхоны усны хэрэглээг гадаргын уснаас хангана.</td></tr>
</table>

| | |
|---|---|
| Аянгаас хамгаалах байгууламж | Уурхайн шатах тослох материалын агуулах болон засварын талбайг аянгын хамгаалалтын төхөөрөмж, түүнийг ашиглах журмын дагуу шатах тослох материалын агуулах ба засварын талбай нь аянгын шууд цохилтоос хамгаалагдсан байна.<br><br>Шатах тослох материалын агуулах ба засварын талбайн аянгаас аянгаас хамгаалах байгууламж: Аянгын шууд цохилтоос хамгаалах зорилгоор аянга хүлээн авагч, гүйдэл зайлуулагч, газардуулгын голчтой савхан аянга зайлуулагчийг байрлуулан гүйцэтгэнэ. Аянга зайлуулагч нь өөр өөрийн газардуулгатай байна. ШТМ-ын агуулах болон засварын талбай нь анхдагч болон хоёрдогч аянгын цохилтоос хамгаалагдсан байх ёстой. Анхдагч аянгын цохилтоос хамгаалах аянга зайлуулагч нь талбайгаас зайтай тусдаа газардуулгатай байх ёстой. Газардуулга нь Ø−12мм, 5 м–ийн урттай төмөр хоолой буюу эсвэл 50*50*5 мм, 3 м–ийн урттай гурвалжин төмрөөр хийгдсэн байх ба газрын гүнд 0.8 м-т 40*4 мм2 төмөр туузан ил газардуулгатай холбогдсон байна. |

## 1.6 Төслийн эдийн засгийн тооцоо, ач холбогдол

### 1.6.1 Төслийн эдийн засгийн үр ашиг

Төслийн хугацаанд 1,537.8 мян.м3 хөрс хуулж, 256.47 мян.м3 элс олборлон баяжуулж, 112.84 кг алт олборлон борлуулахаар тусгагдлаа. Төсөлд нэг грамм алтны үнийг Монгол банкны сүүлийн 1 жилийн дундаж үнэ 314.8 мян.төгрөгөөр тооцоолов. Төслийн хугацаанд нийт цэвэр ашиг 12.2 тэрбум төгрөг бөгөөд цаг хугацааны хүчин зүйлийн итгэлцүүрийг 10%иар тооцоход төслийн өнөөгийн үнэ цэнэ 10.067 сая төгрөг байна.

Улс болон орон нутгийн төсөвт төслийн хугацаанд 5.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэх тооцоо гарч байгаа ба энэ нь нийт борлуулалтын орлогын 15.6%-тай тэнцүү байна.

*Хүснэгт 19 Улс орон нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн тооцоо*

| № | Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 1 жил | 2 жил | Нийт жил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Борлуулах алт | кг | 75.59 | 37.25 | 112.84 |
| 2 | Борлуулалтын орлого | сая.төг | 23,800.81 | 11,728.80 | 35,529.61 |
| 3 | АМНАТ, БО-ын 5% | сая.төг | 1,190.04 | 586.44 | 1,776.48 |
| 4 | Газрын төлбөр | сая.төг | 7.04 | 7.04 | 14.07 |
| 5 | Ус ашигласны төлбөр | сая.төг | 183.00 | 108.97 | 291.97 |
| 6 | Тусгай зөвшөөрлийн төлбөр | сая.төг | 1.61 | 1.61 | 3.23 |
| 6.1 | Улсын төсөвт | сая.төг | 0.81 | 0.81 | 1.61 |
| 6.2 | Орон нутгийн төсөвт | сая.төг | 0.81 | 0.81 | 1.61 |
| 7 | Хүн амын орлогын албан татвар | сая.төг | 127.46 | 127.46 | 254.92 |
| 8 | Нийгмийн даатгалын шимтгэл /26%/ | сая.төг | 406.01 | 406.01 | 812.01 |
| 9 | Орлогын албан татвар | сая.төг | 2,184.16 | 227.52 | 2,411.67 |
| 10 | Тээврийн хэрэглэлийн татвар | сая.төг | 0.90 | 0.9 | 1.80 |
| 11 | Үл хөдлөх хөрөнгийн татвар | сая.төг | 3.60 | 3.6 | 7.20 |
| 12 | Улсын төсөвт төлөх татвар төлбөрүүдийн хэмжээ | сая.төг | 2,462.29 | 881.73 | 3,344.01 |
| 13 | Орон нутгийн төсөвт төлөх татвар, төлбөрүүдийн хэмжээ | сая.төг | 1,641.52 | 587.82 | 2,229.34 |
| 14 | Нийт улс болон орон нутгийн төсөвт төлөх татвар, төлбөрийн дүн | сая.төг | 4,103.81 | 1,469.54 | 5,573.35 |
| 15 | Борлуулалтын орлогод эзлэх хувь | % | 17.24 | 12.53 | 15.69 |

# 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 2.1 Төслийн байгаль орчны төлөв байдал

### 2.1.1 Газрын гадарга, хэвлий.

Жаргалант сум нь далайн түвшөөс дээш 2130м өндөрт байрладаг бөгөөд хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 3257м өргөгдсөн Түжил хайрхан уул юм. Хамгийн нам дор газар нь Давсан талын "Талын хонгор". Тус сум нь газрын нэгдмэл сангийн тойргийн хуваариар Хангай-Хэнтий уулархаг бүс нутагт газар зүйн бүсээр хамаарагдана.

### 2.1.2 Уур амьсгал.

Баянхонгор аймаг нь Монголын баруун өмнөд хэсэгт Хангайн нурууны өмнөх өндөрлөг, Говь Алтайн нурууны уулс, Алтайн өврийн говийг хамран говь хангайн бүсийг дамнан оршдог аймаг юм. Иймд нутаг нь уул тал хөндий хосолсон хэлбэр бүхий гадаргатай юм. Нутгийн хамгийн өндөр цэг нь Говь Алтайн нурууны оргил 3957 м өргөгдсөн Их Богд уул бөгөөд хамгийн нам цэг нь Алтайн өвөр говьд 750 м өндөр юм. Амьтан ургамал Нутгийн хойд хэсэгт ойт хээрийн ургамал, дунд ба урд хэсгээр нь хээрийн говийн ургамал тархжээ. Гоёо, цулхир, вансэмбэрүү, лидэр, алтан гагнуур зэрэг ховор ургамал бий. Баянхонгор аймгийн нутагт манай орны байгалийн энэ гурван бүсэд оршдог амьтад тарвага, үнэг, чоно, ирвэс, аргаль, бор гөрөөс гээд бараг цөм байх бөгөөд дэлхийд нэн ховордсон мазаалай гэх амьтан цөөн тоогоор орших байна.

Судалгааны талбай нь тал хээрийн бүсэд багтах Хангайн нурууны өвөр Баянхонгор аймгийн Заг, Жаргалант сумын нутгаар өвөлдөө - 17° С - -32° С хүйтэн. Зундаа +15° С - + 34° С дулааны хэлбэлзэлтэй юм. Хамгийн их хүйтрэлт 12, 1-р сард болдог ба хамгийн их дулааралт 7, 8-р сард ажиглагдана. Уулархаг нутгаараа жилийн дөрвөн улиралд хур тунадас ихтэй цас бороо их орно. Тал хээрийн бүсдээ хур тунадас харьцангуй бага. Өвлийн цагт харилцан адилгүй 10 -50см зузаантай цасан бүрхүүл тогтож уулархаг газраа 10-р сарын 15-наас дараа оны 4-р сарын 15 хүртэл үргэлжилнэ.

### 2.1.3 Агаарын чанар.

Уурхайн бүсэд PM1.0 ширхэглэгтэй тоосны нягтшил 12-аас 18 мкг/м$^3$, PM2.5 ширхэглэгтэй тоосны нягтшил 20-ээс 25 мкг/м$^3$, PM10.0 ширхэглэгтэй тоосны нягтшил 33-ээс 50 мкг/м$^3$ байгаа нь Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016) стандартын хүлцэх агууламжаас нэн бага байна.

Дээрх үр дүнгээс үзэхэд гадаад орчны агаар дахь тоосонцрын хэмжээ “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016” стандартад заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Төслийн талбай дотор авсан дуу шуугианы хэмжээ мөн адил дБА байгаа нь MNS 4585:2016 Агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна.

### 2.1.4 Геологийн тогтоц ба геоморфологи.

Бөөргийн амны урт нь 10км орчим бөгөөд үүнээс амны адгийн 2-3км хэсэг нь Мандалын голоос түрж ирсэн мөстлөгийн төгсгөлийн мореноор дарагдсан байдаг. Алтны шороон хуримтлал үүсэх боломжтой хэсгийн хөндлөн зүсэлтииг авч үзвэл ихэнх тохиолдолд тэгш хэмтэй, амны дээд хэсэгтээ V хэлбэртэй нарийссан байх 6а дунд хэсэгтээ арай өргөссөн тэгш бус хэмтэй, харин доод хэсэгтээ U хэлбэрийн төрхтэй байна. Хөндийн дундаас доош хэсэгт маш муу ялгарсан 2 дэнж ялгаж болох юм.

Гольдролын дээрх нэгдүгээр дэнжийг 62-р шугамаас доош, үлдэгдэл маягийн, хажуугийн хурдсаар дарагдан маш муу ялгарсан өндөр дэнжийн фрагментуудыг 56-р шугамаас доош ажиглах боломжтой. Гольдролын дээрх нэгдүгээр дэнж нь 1,0-1,5м өндөртэй харин үлдэгдэл хоёрдугаар өндөр дэнж нь 5-8м хүртэл өндөртэй байдаг. Бөөргийн ам нь байнгын устай жижиг голтой бөгөөд энэхүү гол нь ус ховортой хавар намрын улиралд Мандалын голд усаа хүргэж чадалгүй шургадаг ба ус ихэссэн зуны улиралд 2м/сек хуртэл ундрагатай байдаг. Бөөргийн голын гольдрол ассиметр маягаар буюу голдуу хөндийн баруун хэсгийг даган байрлана. Голын хөндийн идэгдлийн гүн 700-800м орчим бөгөөд неотектоник хөдөлгөөний улмаас хөндийн дээд хэсэг доод хэсгээ бодвол илүу өргөгдсөн байна.

Орд нь Бөөргийн амны дундаас дээш хэсэгт байрлах ба 1515м урттай, 64-106м өргөнтэй (дунджаар-84м) хэсэгт 100-200-400х20м-ийн тороор гуйцэтгэсэн хайгуулын ажлаар 4,8-8,3м зузаан хучаастай, 302-12709мг/м3 дундаж агуулгатай 1,2-4,4м зузаан элс тогтоогдов. Ордын дундаж агуулга 875 мг/м ба нөөц нь шлихээр В зэрэглэлээр 162,9кг, С зэрэглэлээр 122,7кг нийи 285,6кг тогтоогдсон ба нөөцийн тооцооны дундаж үзүүлэлтээс үзвэл ордын хэмжээнд хөрс хуулалт дунджаар 6,9м; алттай давхаргын зузаан 2,6м байлаа.

Хайгуулын ажлын өнөөгийн түвшинд ордын дээд ба доод хязгаар тогтоогдоогүй байгаа ба эрлийн 28-р шугамд үйлдвэрийн ач холбогдолтой байхуйцаар (18,4м маш гүнд 1,8м зузаантай, 718мг/мз агуулгатай) давхарга тогтоогдоогүйгээс алттай давхарга нь хайгуулын 60-р шугамаас доош 28-р шугам хуртэлх 3,2км урт хэсгийн хагасаар 1,6км буюу 43-р шугам хуртэл; 72-р шугамаас дээш геологи-геоморфологийн тогтцын хувьд шороон хуримтлал үүсэх бүрэн боломжтой, амны эхний хоёр жижиг салааны уулзвар хуртэл 2,2км урттай хэсгийн хагас буюу 1,0км хэсэгт С+Р1; үлдсэн хэсэгт нь Р1 зэрэглэлээр хэтийн төлвийн үнэлгээ өгсөн болно. Давхаргын өргөн блокуудад 64-106м-ийн хооронд хэлбэлзэж дунджаар 84м байгаа нь тийм ч нарийн биш юм. Хөрсний зузаан нөөц тооцсон хэсгийн доод хэсэг буюу 64-р шугамаас доош 7,2-8,0м хүртэл зузаан байхад 68-р шугамаас дээш хэсэгт 6,4-6,9м-ийн хооронд тогтвортой байгаа.

### 2.1.5 Гадаргын болон газрын доор ус.

Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газар нь Монгол орны баруун өмнөд хэсэгт Хангайн нурууны өмнөд өндөрлөг, Говь-Алтайн нурууны уулс, Алтайн өвөр говийг хамран говь-хангайн бүсийг дамнан оршдог. Алтайн уулархаг их мужийн шинж давамгайлах ба сав газрын өмнөд зүүн өмнөд хэсгүүдэд Алтайн өвөр говийн мужийн шинж илэрдэг.

Тус сав газар нь Алтайн нурууны уулс, Хангайн уулархаг их мужийн дэд муж болох далайн түвшнээс дээш 2000–3000 м өндөрт өргөгдсөн Хангайн нурууны салбар уулсын хэсэгт хамаардаг. Уг мужид байрлах Нууруудын хөндийн хамгийн том нуур болох Бөөнцагаан нуур тус сав газарт багтана. Хангайн нурууны өмнөд хэсэгт нарийн зурвас байдлаар тархан, өндөрлөг нь огцом буурч, бүр толгодорхог төрхтэй болсон уулстай. Дундаж өндөрлөг нь 1800-2000 м хүрч намсах ба урагшаа говийн нурууны хөндий рүү дөхөхөд улам намссаар тэгшдүү зоо болдог. Төслийн талбайн ойр орчимд гадаргын ус байхгүй болно.

Шинжлүүлсэн бүх үзүүлэлтүүд нь Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2018 стандарттай харьцуулахад стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна. Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь унд, ахуйн хэрэглээний уснаас жилд 1 удаа мэргэжлийн

байгууллагаар усны сорьц авхуулж, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх шаардлагатай.

### 2.1.6 Хөрсөн бүрхэвч.

Төсөл хэрэгжих талбай орчмын бүс нутаг нь өндөр уулын хээр бүхий экосистемтэй, д.тд 2400-2500 м үнэмлэхүй өндөртэй уул бүхий газарт байрлах бөгөөд хөрсөн бүрхэвч нь хад чулуу болон Уулын хээрийн хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг нимгэн ба сайргархаг Хархүрэн, чулуурхаг Харшороон төрлийн хөрснүүд тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин дундаас их буюу ялзмагийн агууламж нь 3-7.8%, нимгэндүү үе давхаргатай, хөрс үүсгэгч хурдас нь том жижиг чулуу болон нарийн элсэрхэг ба шаварлаг хагшаастай, хэврэгдүү бүтэцтэй учраас шороон зам зэрэг техникийн нөлөөтэй эвдрэл талхагдалд тэсвэр дунд зэрэг, эргэж нөхөн сэргэхдээ мөн удаавтар байна. Талбайн ерөнхий онцлог нь хонхор хотос болон гуу жалга бүхий газруудад салхины ба усны нөлөөгөөр зөөгдөж ирсэн элсэрхэг болон тоосорхог хурдас хуримтлалтай, гүвээрхэг хэсгээрээ чулуурхаг ба сайргархаг, нугачаа хэрчигдэл ихтэй байна. Хүний үйл ажиллагааны нөлөөтэй эвдрэл талхагдал одоогоор дунд зэрэг байна. Газрын гадаргын геоморфологийн хэлбэр нь уул үүслийн атираашил гаралтай, хэмжээний хувьд макро рельефийн төрөлд хамаарах бөгөөд талбайн ойр орчмын уулс ус салхины нөлөөгөөр элэгдэж хуримтлагдах замаар үүссэн байна.

Хөрсний үржил шимийн түвшнийг тодорхойлдог голлох үзүүлэлт болох хөрсний ялзмаг, хөдөлгөөнт фосфор, кали болон хөрсний хими шинж чанарын үзүүлэлт болох хөрсний урвалын орчин (pH), карбонатын агууламж, хөрсний хялбар уусах давсжилт (EC) гэсэн үзүүлэлтүүдийг тодорхойлсон бөгөөд үзүүлэлт тус бүрийн үр дүнгийн талаар доор дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Төслийн нийт талбайн хэмжээнд одоогоор уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр болон барилга байгууламж зам талбайд өртсөн нийт 20.6 га газар байна. Эдгээр нь нийт төслийн талбайн 28% болж байна. Гэхдээ үүнээс техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн талбай 16.7 га байна.

Хортой хүнд металл гэдэгт дараах 6 хүнд металл багтана. Үүнд: Хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), зэс (Cu) орно. Эдгээрээс Cd, Cr, Pb нь онцгой хортой, Co, Cu, Ni, Zn нь хортой био-идэвхт хүнд металлууд гэж үздэг. Онцгой хортой хүнд металлууд нь амьд организмд учруулах хор нөлөөлөл ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхүүлэх хүртэл аюултай байдаг. Харин хортой био-идэвхт хүнд металлууд нь хоруу чанарын хувьд онцгой хортой хүнд металлуудаас арай бага, тодорхой хэмжээгээр амьд организмд байх ёстой боловч амьд организмд их хэмжээгээр хуримтлагдвал эндемик буюу орогномол өвчин үүсгэдэг аюултай. Судалгааны үр дүнгээс харахад онцгой хортой хүнд металлуудаас кадми (Cd) маш бага буюу бараг илрээгүй байна. Бусад металлууд стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу хэвийн түвшинд байна.

### 2.1.7 Ургамлан бүрхэвч.

Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутагт байрлах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Хангайн уулын ойт хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Монгол орны төв хэсэг болох Хангайн уулархаг бүс нутгаас ба баруун хойноос зүүн урагш чиглэсэн, уртаараа 600 орчим км, хойш Хөвсгөл нуур хүртэлх өргөн уудам нутгийг хамаарна.

Энэ тойрогт 1551 зүйл (Urgamal et al. 2016) гуурст ургамал ургадаг бөгөөд Сибирийн тайгын элементүүд, нөгөө талаас Монголын хээрийн төлөөлөгчид бас Дагуурын элементүүд нэвтэрч байршсанаас уулын хээр, ойн бүслүүр ээлжлэн солигдоно. Хангайн нурууны тагт Алтай-Саяаны өндөр уулын элементүүд нэлээд бий. Энэ тойргийн ургамлын аймаг нь Алтай Соѐны өндөр уулын ургамлаас гадна Дагуур-Монголын хээрийн ургамал оролцсон өвөрмөц холимог бүтэцтэй, өөрийн унаган ургамал болон түгээмэл тархац бүхий зүйлүүдтэй юм. Зөвхөн энэ тойрогт тохиолдох 45 зүйл (Urgamal et al. 2016) ургамал тэмдэглэгджээ. Хангайн тойргийн үндсэн төрхийг үзүүлэгч ургамлуудад: Хангайн хумилж (Alchemilia changaica), Хангайн хунчир (Astragalus changaica), Юлдэн шүүдрийн-ойм (Botrychium lanceolatum), Төгрөгнавчит хус (Betula rotundifolia), Сөөгөн хус (Betula fruticosa), Алирс (Vaccinium vitis-idaea), Монгол хундгана (Adonis mongolica), Юнатовын шивэлз (Ptilagrostis junatovii), Павловын сорвоо (Calamagrostis pavlovii), Час-улаан шивэлгэнэ (Selaginella sanguinolenta), Тагийн биелэг (Poa alpina), Кудой улаантолгой (Agrostis kudoi), Нарийннавчит улалж (Carex tenuiflora), Ороонго хорс (Acontium volubile), Цийрнавчит сарнай (Rosa pimpinellifolia), Клеменц ортууз (Oxytropis klementzii), Монгол ганга (Thymus mongolicus), Нүцгэн шүхэргэнэ (Cenolophium denudatum), Хангайн шарилж (Artemisia changaica), Монгол багваахай (Taraxacum mongolicum), Алтайн нил (Viola altaica) зэрэг орно.

Төслийн талбай нь ойт хээр, уулын хээрийн ургамалжилтай. Манай оронд тархсан уулын хээрийн ноёлогч ургамлуудад Ботууль *(Festuca lenensis),* Даагансүүл *(Koeleria macrantha*), Биелэг *(Pao attenuatta)* зэрэг жижиг дэгнүүлт үетнүүд, мөн Зүр *өвс (Filifolium sibiricum)* орно. Харин Нангиад Түнгэ (*Leymus chinensis*), Крыловын хялганат (*Stipa krylovii,)*, Дэрвээн хазаар өвс *(Cleistogenes squarrosa),* Ерхөг *(Agropyron cristatum)* зэрэг хуурай хээрийн зонхилогч үетнүүдийн арви уулын хээр ба хуурай хээрийн шилжилтийн зааг нутгаар нэмэгдэж дэд зонхилогчийн үүрэгтэй болно (И.Түвшинтогтох, 2014.).

### 2.1.8 Амьтны аймаг.

Баянхонгор аймгийн Жаргалант сумын 3-р багийн нутагт орших “Жамп” ХХК-ийн “Бөөргийн амны” алтны шороон орд орчимд тохиолдох амьтдын зүйлийн бүрдлийг хээрийн судалгааны материал, санал асуулгын үр дүн, өмнө хийгдсэн судалгаа, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон Gombobaatar et al (2011), Terbish et al (2013), Батсайхан нар (2022), Gombobaatar (2022) зэрэг бүтээлтэй харьцуулан гаргасан ба 4 зүйлийн хоёр нутагтан, мөлхөгч, 78 зүйлийн шувуу, 31 зүйлийн хөхтөн амьтан тохиолдоно.

Энэ бүс нутагт тохиолдох амьтад Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан данс (2006), Монгол улсын хөхтөн амьтны улаан данс (2006), Монгол орны шувуудын улаан данс (2011), Монгол улсын Улаан ном (2016), Олон улсын конвенциуд болон Монгол улсын хууль тогтоомжоор тус тус хамгаалагдана.

Төслийн талбай нь Баянхонгор аймгийн Жаргалант сумын Хөндлөн булаг 3-р багийн нутаг Бөөргийн нурууны баруун ам болох Бөөргийн гол дагуу 74.17 га талбайтай. Энэ орчмын нутаг нь Хангайн гол нурууны өмнөд өндөр уул нуруud, мөсөн голын үйлдлээр үүссэн талын хэв шинжтэй. Байгалийн бүс, бүслүүрийн хувьд өндөр уулын нуга, тундрын бүслүүрт багтана. Монгол орны-физик газарзүйн мужлалтаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хангайн мужийн Хангайн гол нурууны тойрогт хамаарна.

### 2.1.9 Тусгай хамгаалалттай газар нутаг.

Баянхонгор аймагт нийт найман Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд байх ба Жаргалан сумынд Заг байдрагийн голын эхэн сав- БЦГ байна. Баянхонгор аймгийн Жаргалант суманд 16 орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд байрласан байна.

Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутагт орших “Жамп” ХХК-ийн “Бөөргийн ам”-ийн алтны шороон ордыг ашиглах төсөл нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

**2.1.10 Түүх соёлын өв.**

Улсын хэмжээнд 13 түүх соёлын үл хөдлөх дурсгал байх Жаргалант сумын хэмжээнд давхцалгүй ба Аймгийн хэмжээнд 54-н түүх, соёлын үл хөдлөх дурсгал байх ба үүнээс Жаргалант сумын хэмжээнд 2 түүх соёлын үл хөдлөх өв бүртгэгдсэн байна.

**2.1.11 Нийгэм эдийн засаг.**

Жаргалант нь 1940 онд Заг сумаас салж Байдрагийн үржлийн сангийн аж ахуйг түшиглэн байгуулагджээ. Байдраг үржлийн сангийн аж ахуй нь нарийн, нарийвтар ноосны чиглэлийн хонин сүргийн бүтцийг шинээр бий болгож түүнийгээ “Чамаар” (Байдраг) үүлдрийн хонь гэж нэрлэсэн. Энэхүү сангийн аж ахуй нь тухайн үедээ "Эрдэнэт хивс" компанид ноосоо нийлүүлдэг байсан ба Эрдэнэт хивсний үндсэн түүхий эд нь мөнөөх нарийн нарийвтар урт ноос юм. Жаргалант сум нь Байдрагийн сангийн аж ахуйг түшиглэн байгуулагдсан болохоор нийт монголчууд Жаргалант гэхээсээ илүүтэйгээр Байдраг гэж нэрийдэх болжээ. Засаг захиргааны нэгжийн хувьд 4 багт хуваагдах бөгөөд 1-р багийг Нам толгойн баг, 2-р багийг Өлзийт өндрийн баг, 3-р багийг Хөндлөн булгийн баг, 4-р багийг Эмээл толгойн баг гэнэ.

Сумын хэмжээнд 2023 онд 4199 хүн амьдарч байгаа ба өмнөх онуудтай харьцуулахад 0.78% буурсан үзүүлэлттэй байна.

Малын бүтэц 2023 оны жилийн эцсээр адуу 22.45 мян.толгой, үхэр 39.11 мян.толгой, хонь 121.35 мян.толгой, ямаа 92.2 мян.толгой, тэмээ 0.1 мян.толгой тус тус тоологдсон ба сумын хэмжээнд 275.19 мян.толгой мал тоологдсон байна.

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨ

## 3.1 Төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүд

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОУАӨЯ-ны шинжээчийн 2025 оны 07-р сарын 09-ний өдрийн 2025/OA-71 тоот дугаартай БОУАӨЯ-ны 2025 оны 07-р сарын 24-ний өдрийн 12/3759 тоот дугаартай албан бичгээр баталгаажуулсан Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гарсан байна.

### 3.1.1 БОНЕҮ-ний дүгнэлтийн шаардлага

БОНЕҮ-ний дүгнэлтэд тусгасан гол шалгуурууд болон урьдчилан тодорхойлсон сөрөг нөлөөллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 20. Байгаль орчны сөрөг нөлөөллийн үзүүлэлтүүд*

| № | Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлага | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу боловсруулах; | Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2023 оны 02-дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, зэрэг эрхзүйн баримтуудыг үндэслэж “Дойтын булаг” ХХК хийж гүйцэтгэв. |
| 2 | Усны эх үүсвэрийг тодорхойлж, ашиглах усны хэрэгцээг тогтоосон аргачлал нормын дагуу тооцож, ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах | Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30 ны өдрийн А/301 дугаар тушаалын хавсралтаар усны тооцоог хийн усны боломжит нөөцийн дүгнэлтийг гаргуулсан болно. |
| 3 | Хөрсний элэгдэл, эвдрэлийн байдлыг бүрэн тодорхойлж, үйлдвэрийн үйл ажиллагааны явцад хөрсний элэгдэл, эвдрэлээс сэргийлэх арга хэмжээ, шаардагдах хөрөнгө оруулалтыг төлөвлөж, холбогдох стандартын дагуу байгаль орчныг хамгаалахад шаардлагдах зардлыг тооцох | Тайлангийн 4-р бүлэгт холбогдох нөлөөлийг тодорхойлж үнэлэн, 5-р бүлэгт сөрөг нөлөөг бууруулах зөвлөмжийг боловсруулсан. Мөн БОМТ-ын хэсэгт зардлыг тусгаж өгсөн. |
| 4 | Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS5850:2019 стандарт заасан органик биш 18, органик 5 бодисыг нөлөөлөлд өртөх талбай, нөлөөллийн бүсийн ойролцоох талбайн хөрсөнд бүрэн шинжилж, шинжилгээний дүнг тайланд тусгах | Тайлангийн 4-р бүлэгийн 4.2.1 т Хөрсний хүнд металлын өнөөгийн түвшинг тодорхойлж өгсөн. |
| 5 | Төслийн нөлөөллийн бүсэд “Агаар байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS5885:2008 стандартад заасан бохирдуулагч бодисыг бүрэн шинжилж, үр дүнг тайланд тусгах | Тайлангийн 4-р бүлэгт холбогдох нөлөөлийг тодорхойлж үнэлэн, 5-р бүлэгт сөрөг нөлөөг бууруулах зөвлөмжийг боловсруулсан |
| 6 | Төслөөс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй болон сөрөг нөлөөллийг тодорхойлж үнэлэх | Тайлангийн 4-р бүлэгт холбогдох нөлөөлийг тодорхойлж үнэлэн, 5-р бүлэгт сөрөг нөлөөг бууруулах зөвлөмжийг боловсруулсан |
| 7 | Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг нарийвчлан гаргах | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил тус бүрээр зардлыг тооцсон |
| 8 | Төслийн үйл ажиллагааны явцад унд ахуйд ашиглах цэвэр усны хэрэглээний хэмжээг эх үүсвэртэй уялдуулан, түүнээс гарах ахуйн бохир усыг тус тус нарийвчлан тооцох, түүнчлэн | Тайлангийн 4-р бүлэгт холбогдох нөлөөлийг тодорхойлж үнэлэн, 5-р бүлэгт сөрөг нөлөөг бууруулах зөвлөмжийг боловсруулсан |

| | | |
|---|---|---|
| | хог хаягдлын менежментийн асуудлыг бүлэг болгон байгаль орчинд халгүйгээр зайлуулах аргыг нарийвчлан тодорхойлох | |
| **9** | БОУАӨ-ийн сайд, ХЗДХ-ийн сайдын хамтарсан 2025 оны А/37, А/31 дүгээр тушаалаар батлагдсан “Хүрээлэн байгаа орчны хохирол тооцох аргачлал”-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас учруулах хохирлыг байгалийн бүрдэл тус бүрээр урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган төслийг хэрэгжүүлэх байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодруулж дүгнэлт боловсруулах | Экологи эдийн засгийн хохирлын үнэлгээг Бүлэг 6т тооцон өгч нийт зардлыг гаргасан |
| **10** | Төслийн үйл ажиллагааны явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажиллагчдын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн талаар зөвлөмж, дүгнэлт боловсруулах | Тайлангийн 7-р бүлэгт холбогдох нөлөөлийг тодорхойлж үнэлэн, дэлгэрэнгүй тусгасан |
| **11** | Холбогдох хуульд нийцүүлэн эрх бүхий байгууллагаар баталгаажсан барилга байгууламжийн зураг төсөл, тухайн газарт хэрэгжих төслийн талаарх мэдээлэл, шинжилгээний дүн мэдээ, газрын гэрээ, гэрчилгээ, тооцоо нийлсэн баримт зэргийг тус тайланд хавсаргах | Холбогдох материалыг хавсаргасан |
| **12** | "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 101-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах; | БОМТ тусгасан болно |
| **13** | Төсөлд ашиглах химийн бодис, сав баглаа боодлыг хэрхэн хадгалах, ашиглах импортлох талаар нарийвчлан тусгаж, химийн бодисын эрсдэлийн үнэлгээ хийх | Химийн бодис ашиглахгүй, гравитацын аргаар баяжуулна. |
| **14** | Төслийн явцад гарах аюултай хог хаягдлыг зөвшөөрөлтэй аж ахуйн байгууллагад нийлүүлэн устгах гэрээ, тусгай зөвшөөрлийг хавсаргах | Холбогдох материалыг хавсаргасан |
| **15** | Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу нийгмийн нөлөөллийн үнэлгээг тооцох | Тайлангийн 4-р бүлэгт холбогдох нөлөөлийг тодорхойлж үнэлэн, 5-р бүлэгт сөрөг нөлөөг бууруулах зөвлөмжийг боловсруулсан |
| **16** | Төслий үйл ажиллагаанаас агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах урьдчилан сэргийлэх болон бусад асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулах | Тайлангийн 5-р бүлэгт холбогдох нөлөөлийг бууруулах зөвлөмжийг боловсруулсан |
| **17** | Нарийвчилсан үнэлгээ хийх явцад уг төсөл хэрэгжсэнээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн талаар БОННҮ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих багийн ИНХ хэлэлцүүлэлц, хурлын тэмдэглэл саналыг тайланд хавсаргах | Төслийг ИНХ хурлаар хэлэлцүүлж тогтоол тэмдэглэл авсан, тайланд хавсаргасан |
| **18** | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн хүчин чадалд тулгуурлан мод тарих, модны төрөл зүйл, тоо хэмжээг тайланд тусгах | БОМТ-д тусгаж өгсөн |
| **19** | БОННҮ-нд байгаль орчинд ээлтэй, олон улсын стандартад нийцсэн технологийг ашиглах талаар заавар зөвлөмжийг боловсруулах | Тайлангийн 5-р бүлэгт холбогдох нөлөөлийг бууруулах зөвлөмжийг боловсруулсан |
| **20** | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төслийн хүчин чадал,төслийн үйл ажиллагааны өрнөлтийн байдалтай уялдуулан тооцоолох | БОМТ-д тусгаж өгсөн |

Дүгнэлт: Уурхайн ашиглалтын үед үүсэх нөлөөллийг үнэлж үзэхэд том хөхтөн болон зэрлэг ан амьтан, мөлхөгч, мэрэгч, шувуунд дундаас их эрчимтэй сөрөг нөлөөтэй байна. Сөрөг нөлөөллийг бууруулах, зайлсхийх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр төслийн зүгээс амьтдын амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл урт хугацаанд бага зэрэг буюу ноцтой хэмжээнд биш гэж үзэв.

## 3.2 Төслөөс орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Төслөөс Баянхонгор аймгийн Жаргалант сумын нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийг доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 21. Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөлөл*

| *Нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн* | *Төслөөс учирч болзошгүй нөлөөлөл* | |
|---|---|---|
| | *Эерэг нөлөөлөл* | *Сөрөг нөлөөлөл* |
| *Нутгийн иргэдэд үзүүлж болзошгүй нөлөөлөл* | | |
| *Ажил эрхлэлт, амьжиргаа* | • | |
| *Шилжилт хөдөлгөөн* | • | |
| *Нүүлгэн шилжүүлэлт* | | |
| *Эдийн засгийн хөгжилд гарч болох нөлөөлөл* | | |
| *Баянхонгор аймаг* | • | |
| *Жаргалант сум* | • | |
| *Дэд бүтэц* | | |
| *Баянхонгор аймаг* | • | |
| *Жаргалант сум* | • | |
| *Соёлын өвд учирч болзошгүй нөлөөлөл* | | |
| *Археологийн дурсгал* | | |
| *Түүх соёлын дурсгалт газар, ТХГН* | | |

### 3.2.1 Төслөөс орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл

Төслөөс орон нутгийн хүн амд үзүүлэх нөлөөллийг ажил эрхлэлт, амьжиргаа, шилжин хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлтийн хувьд авч үзлээ.

Алтны шороон ордыг ашиглах төсөл хэрэгжсэнээр сумын түвшинд ажил эрхлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэж үүнийг дагаад иргэдийн амьжиргаанд эерэг нөлөөлөл үзүүлнэ. Мөн уурхайг урьдчилсан байдлаар 2 жилийн хугацаанд ашиглах бөгөөд орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл нь урт хугацааны шинж чанартай байхаар байна.

### 3.2.2 Төслөөс орон нутгийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжсэнээр нөлөөллийн бүсийн сумын эдийн засагт дараах байдлаар шууд болон шууд бус эерэг нөлөөллүүд үзүүлнэ. Эдгээрт:

- Ажил эрхлэлт нэмэгдэх
- Уурхайд бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлснээр орлого нэмэгдэх, иргэдийн амьжиргаа сайжрах
- Сумын орлогын эх үүсвэр бэхжих
- Бизнес хөгжихөд таатай орчин бүрдэх

### 3.2.3 Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөө

Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд ямар нэг түүх, соёлын өв, дурсгал зүйлс байхгүй тул сөрөг нөлөө тодорхойлогдохгүй. Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүх соёлын дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.

### 3.2.4 Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөө

Төслийн талбайн ойр орчимд улсын тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй бөгөөд Төсөл хэрэгжиж буй талбай нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд давхцалгүй байна.




*Зураг 17. Улсын тусгай хамгаалалтай газар нутгууд*

Баянхонгор аймагт нийт найман Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд байх ба Жаргалан сумынд Заг байдрагийн голын эхэн сав- БЦГ байна. Төслийн талбай нь улсын тусгай хамгаалалтай газар нутагтай давхцалгүй байна.

### 3.2.5 Төслийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ

БОНХЯ-ны сайдын (хуучин нэрээр) 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалд заасан аргачлалын дагуу нөлөөллийн индексийг ашиглан амьдрах орчинд үзүүлэх төслийн нөлөөллийг тооцоолох “ГЗМС” дээр тулгуурласан “Нөлөөлөл орон зайд буурах функц”-ийг ашиглан нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тооцож гаргав.

Судалгааны мэдээлэл боловсруулах арга: ArcGIS 10.8 программын MDT хэрэглүүрийг ашиглан боловсруулсан.

Нөлөөлөл буурах функцийн үр дүнгээр төслийн орчны бүсийн үнэлгээ буюу хуримтлагдаг нийт нөлөөллийн тооцоход 62.43 га талбай байна. Үүнийг нөлөөллийн эрчмийг талбайгаар авч үзвэл 19.03 га их, 7.53 га дунд, 35.87 га бага хамрагдаж байна.




*Зураг 18. Нөлөөллийн эрчмийн зураглал*

# 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 22. 2025 онд сөрөг нөлөөллөөс бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | 2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | | |
| **1** | Орчны агаарын чанар хорт хий, хүнд металлаар бохирдох | Уурхайн бүх тээврийн хэрэгслийн яндангаас гарах хорт хийд тогтмол хяналт тавих, бохирдлыг хэмжих | Төслийн үйл ажиллагааны туршид ашиглаж байгаа машин механизмыг тогтмол үзлэг оношилгоонд хамруулж ажилласан. Тос маслог 5000 мото цаг тутамд сольсон, 10.000 мото цаг тутамд гидерийн шингэн сольж бүх утааны яндanд шүүлтүүр суурилуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| **2** | | Тээврийн хэрэгслийн хурдны хяналтыг мөрдөж ажиллах, хурд хязгаарлах тэмдэг тэмдэглэгээг тавьж өгөх, засаж сайжруулж байх | Судалгааны дүнд шороон замаар зорчих тээврийн хэрэгслийн хурдыг 40км/цаг-р хязгаарлахад тоосжилтыг бууруулах үр ашиг нь 44% орчим байна тиймээс тус арга хэмжээг авахаас гадна тээврийн хэрэгслүүдийн зорчих замыг нарийн зохион байгуулах нэг зам нэг чиглэлийг барьж байгаа ба Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөн зохион байгуулалтыг ойлгомжтой болгох зорилгоор дараах ил харааны тэмдэгт, тэмдэглэгээ/Хурд заасан, хориглосон, чиглэл заасан, объектын байршил заасан, анхааруулсан/-г шаардлагатай газарт байрлуулах ба замд тавигдах тэмдгийн байрлал, тоо хэмжээ, төрөл, хэлбэр дүрсийг тодорхой байлгах үүднээс үндсэн ангилал тус бүрд Монгол улсын стандарт MNS 4597-2003-д заасан стандартын дагуу ажилтны ажилд ирэх, буцах зам аюултай хэсэг болон аюул, осол гарч болзошгүй газруудад анхааруулах тэмдэг, зурагт | 2,320,000.0 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хуудас болон машин тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны заавар санамжийг ил тод харагдах газарт бүрэн байршуулав. | |
| **3** | | БОННҮ-д тусгасан дотоод болон гадаад тээврийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээнүүдийг/тоос дарагч бодис, төхөөрөмж, усалгаа, ажлын талбай болон замыг урьдчилан бэлтгэх/ авч хэрэгжүүлэх салхи ихтэй хуурайшилттай үед онцгой анхааралтай нэмэлт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх | Шороон замаар зорчих тээврийн хэрэгслийн хурдыг 40км/цаг-р хязгаарлахад тоосжилтыг бууруулах үр ашиг нь 44% орчим байна тиймээс тус арга хэмжээг авахаас гадна өдөр тутмын үйл ажиллагаандаа уурхайн дотоод замуудыг нягтруулан, сайжруулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн. Салхи ихтэй үед ажлыг зогсоож машины хурдыг хязгаарлах, ус шүршигч машин ажиллуулах арга хэмжээнүүдийг тогтмол авч ажиллаж байна. Тээврийн хэрэгслийн хурдны хяналтыг мөрдөж ажиллах, хурд хязгаарлах тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газар тавьж өгсөн байна. | Үйл ажиллагааны зардлаар |
| **Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | |
| **4** | Усан орчин бохирдох,<br><br>Усны нөөц хомсдох | Ус ашиглах дүгнэлт, гэрээг байгуулж ажиллах. Төсөл хэрэгжүүлэгч нь “Усны тухай хууль” –ийн 28.4 –р зүйлд заасны дагуу “Ус ашиглах дүгнэлт” -ийг Усны газар, аймгийн байгаль орчны албанаас гаргуулна. Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг Сумын Засаг даргатай холбогдох гэрээг байгуулж ажиллах шаардлагатай. | Унд ахуйн болон технологийн хэрэглээний усыг Бөөргийн голоос ашигласан ба гадаргын усны тайлан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. | 5000,000 |
| **5** | | | ОХШ хөтөлбөрийн хүрээнд гадаргын уснаас шинжилгээ авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. | 225,000 |
| **Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | |
| **6** | Хөрсний бохирдол | Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах | Кемп, оффисын барилгыг засварлаж сэргээсэн. Гадна талбайг цэвэрлэж тохижилтын ажлын нэмж хийсэн. Уурхайн хотхон хэсэгт Гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээ тогтмол хийж, орчны тохижилтыг сайжруулан, сумын хогийн төлбөрийг төлж баргадуулсан. | 1,200,000.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **7** | | Тээврийн хэрэгслийн болон явган хүний зам, зогсоол байгуулах, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, хаалт хамгаалалт хийх, уурхайн хил хязгаар тогтоох | Төслийн талбай болон түүний ойр орчимд ажилчид болон амрагчдад зориулан зам талбайн тэмдэгжүүлэлтийг байршуулсан.<br>Машины зогсоолыг уурхайн түр хотхоны урд талд түр зогсоолын талбай байгуулан тэмдэгжүүлсэн. | 500,000.0 |
| **8** | | Хөрсөн орчны мониторинг судалгааг хийх | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажил хийлгэхээр 2025 оны 09-дүгээр сарын 09-ний өдрийн ХББ/25/08 тоот гэрээг Дойтын булаг ХХК-тай байгуулан хийж гүйцэтгүүлж байна. | ОХШХ-ийн зардлаар |
| **9** | | Авто машины зогсоол дээр асгарсан тос, тосолгооны материалыг тухай бүрд нь цэвэрлэж авах | Төслийн үйл ажиллагааны явцад дээр шатах тослох материалын сав баглаа боодол, засвар машин механизмын засвар үйлчилгээнээс гарсан шатах тослох материал арчих алчуур, ажилласан тос масло гарах бөгөөд засварын цехийн хажууд аюултай хог хаягдал түр байршуулах, цуглуулах цэг тохижуулсан. | 800,000.0 |
| **10** | | Төлөвлөгөөнд тусгаагүй газар талбайд нөлөөлөл учруулахгүй байхаар уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хянаж явуулах. | ТЭЗҮ-д тусгасны дагуу олборлолтын талбай, уурхайн хотхоны талбай, ШТС, засварын талбай, пүү, орц гарцын хэсэг гэх мэт томоохон төлөвлөлтүүдийн дагуу, уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажил үйлчилгээг явуулж байна. | Үйл ажиллагааны зардал |
| **11** | | Үржил шимт хөрсийг хуулж хуулж авсан шимт хөрсийг технологийн дагуу хадгалах | Төслийн үйл ажиллагаанаас шууд нөлөөлөлд өртөх газрын гадаргын шимт хөрсийг хуулж, MNS 5916:2008 стандартын дагуу хадгалах, хөрсний овоолгыг MNS 5917:2008 стандартын шаардлагын дагуу налуулан овоолгыг үүсгэсэн. | Үйл ажиллагааны зардал |
| **12** | | Нефтийн бүтээгдэхүүн бүхий хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, бохирдсон хөрсийг тухай бүрд нь цэвэрлэж байх | Төслийн явцад хөрсийг ахуйн болон хатуу хог хаягдал болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх бүхий л арга хэмжээг авч ажилласан. Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж, цардаж өнгөлсөн, тэмдэгжүүлсэн. | Үйл ажиллагааны зардал |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | |
| **13** | Ургамал | Шимт хөрсийг стандартын дагуу хуулах, овоолго үүсгэх | Ногоон байгууламж, явган хүний зам, олон нийтийн амралт, тоглоомын талбай, тээврийн зогсоолд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.<br>Төслийн үйл ажиллагаанаас шууд нөлөөлөлд өртөх газрын гадаргын шимт хөрсийг хуулж, MNS 5916:2008 стандартын дагуу хадгалах, хөрсний овоолгыг MNS 5917:2008 стандартын шаардлагын дагуу налуулан овоолгыг үүсгэсэн. | Үйл ажиллагааны зардал |
| **14** | | Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, хяналт тавих | Бүх ажилчид, туслан гүйцэтгэгч ХХК-ийн ажилчдад ХХАБ хог хаягдал ангилан ялгах, хууль бус ан амьтан агнахгүй байх анхааруулга сургалтыг тогтмол явуулж ажилласан. Мөн ирж буй явж буй зочдын машин эд хэрэгсэлд хяналт хийж орж гарч зорчиход тогтмол хяналт тавьж ажилласан мөн л сургалтыг ХХАБ сургалттай хамт зааж зааварчилгаар хүргүүлж ажилласан. | Үйл ажиллагааны зардал |
| **Эрчим хүч** | | | | |
| **15** | Цахилгаан эрчим хүчний хэрэглээ | Сэргээгдэх эрчим хүчийг илүүтэй сонгож хэрэглэх | Уурхайн хотхон болон харуулын байр, бүх хяналтын камер нарны зайн цахилгаан эх үүсгэврийг ашиглаж байгаа. | 3,730,000.00 |
| **Нийт дүн** | | | | **13,775,000** |

## 5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд төслийн уурхайн үйл ажиллагаа явагдах эхэлж буй бөгөөд энэ жилд шимт хөрсийг хуулах, шимт хөрсийг ачих, тээвэрлэх ажлыг хийнэ. Мөн 1.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэлээ. Нөхөн сэргээлтийн ажилд нийт 21,000,000 сая төгрөгийг зарцуулсан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд төсөл хэрэгжүүлэгч нь орон нутагт жил бүр 1000 мод тарихаар төлөвлөсөн нь цаг хугацааны нөхцөл байдлын улмаас 2025 оны модыг сум орон нутагтай санал солилцож төв суурин газарт суулгах санхүүжилтийг бүрэн /5000,000/ төгрөгийн барагдуулсан.

# 6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэдэг нь төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг уурхайн 2 дах жилээс хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн ба 2026 оны эхний улиралд мэргэжлийн байгууллагаар төлөвлөгөө батлуулж төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ажлыг хийж гүйцэтгэнэ.

# 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тусгай зөвшөөрлийн талбайд И. Уламбаярын өвөлжөө зуслангийн газар байгаа учир нөхөн олговор нөлөөллийг бууруулахтай холбоотой асуудлыг Ашигт малтмалын тухай хуулийн 41.1 газар болон бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой өмчлөх, хуваарилах, бэлэглэх, шилжүүлэх үйл явцыг Монгол улсад дараах хууль тогтоомжуудаар зохицуулна. Үүнд: Үндсэн хууль (1992), Газрын тухай хууль (2002 нэмэлт өөрчлөлт 2017.06.09), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003, нэмэлт өөрчлөлт 2017.02.02), Иргэний тухай хууль (2002, нэмэлт өөрчлөлт 2017.05.18) зэрэгт үндэслэн хуулийн хүрээнд шийдвэрлэж 2 талын нууцлалын зэрэгтэй гэрээ байгуулсны дагуу нөлөөллийн асуудлыг бүрэн шийдвэрлэлээ.

# 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 23. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | 2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | Нийт зардал |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| **1** | Археологийн болон Палеонтологийн дурсгал | Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой. | Төслийн талбайд соёлын биет өв илрээгүй болно. | - |
| **Нийт дүн** | | | | - |

# 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 24. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө биелэлт*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | 2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Байгалийн аюул гамшиг | | | | | |
| 1 | Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох | Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах | Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргаж ажилчдад аюул ослын сургалт орсон. | Дотоод зардал<br>Үйл ажиллагааны зардал | |
| Галын аюул | | | | | |
| 2 | Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагаа хангаагүйгээс галын аюул гарах | Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах; | Галын аюул гарч болзошгүй цэгүүдэд галын иж бүрэн сараа байрлуулсан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт болон сэрэмжлүүлэг самбар мэдээг ил газар байршуулсан. | 3,000,000.0 | |
| 3 | | Уурхайн болзошгүй үерээс хамгаалах байгууламж (суваг, шуудуу, далан хаалт) барих (www.achhold¬ing.mn) | Шөнийн цагт аюул ослоос сэргийлэхийн тулд 500 ваттын прожектороор харанхуйн гэрэлтүүлгийг 8 ширхгийг уурхайн ажлын талбайд байршуулсан. | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд тусгасан. | |
| 4 | Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагаа хангаагүйгээс галын аюул гарах | Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах; | Галын аюул гарч болзошгүй цэг /ШТС, Засварын шоп, уурхайн хотхон/-т галын иж бүрэн сараа байрлуулсан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт болон сэрэмжлүүлэг самбар мэдээг ил газар байршуулсан. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар | | | | |
| 5 | Төслийн үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх | Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах | ХАБЭА авч ажиллуулан хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан. ХАБЭА хангаж шалгаж өдөр бүр ажлын талбайд гарахаас өмнө аюулгүй ажиллагааны зөвлөмжийг өгч байсан. | Үйл ажиллагааны зардал |
| 6 | | Уурхай нь өөрийн онцлогт тохирсон “Аваар устгах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын дагуу боловсруулсан аваар устгах төлөвлөгөөтэй байна | ХАБЭАжилтан өөрийн онцлогт тохирсон “Аваар устгах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын дагуу боловсруулсан аваар устгах төлөвлөгөөтэй боловсруулан батлуулж мөрдөж ажиллаж байна. | Үйл ажиллагааны зардал |
| 7 | | Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх | Уурхайн ХАБЭА -ын ажилтан ажилд гарахаас өмнө тухайн ээлжийн ажилчдад аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өгдөг. Уурхайн талбайд харагдах орчин хязгаарлагдахаас сэргийлж 500 ваттын прожектороор харанхуйн гэрэлтүүлгийг 8 ширхгийг уурхайн ажлын талбайд байршуулсан. | Сөрөг нөлөөллөөс бууруулах арга хэмжээний зардалд тусгасан |
| 8 | | Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах | Нэг удаагийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хайрцгийг 10 ширхгийг байршуулсан. | 2,500,000.0 |
| 9 | | Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах | Бүх ажилчдыг өвөл зуны хөдөлмөл хамгааллын иж бүрэн хувцсаар хангасан. Эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт хамруулсан. | Үйл ажиллагааны зардал |
| **Нийт дүн** | | | | **5,500,000.0** |

## 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэнд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй. Хог хаягдлыг энгийн, ахуйн, аюултай гэх мэтээр Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан бөгөөд эдгээрийг хэлбэрээр нь хатуу, шингэн, хийн гэж ангилав.

- Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.
- Ахуйн хог хаягдал гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.

Энэхүү БОННҮ-ний тайлангийн 4.8.2-т хог хаягдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийн авна уу. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг 2017 онд батлагдсан Хог хаягдлын тухай хуулийн үзэл баримтлал, зүйл заалтыг үндэслэн боловсруулав.

*Хүснэгт 25. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Хог хаягдлын ангилал | 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажил | 2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | | |
| 1 | Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, ялгах, хог хаягдлыг дахин ашиглах | Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих | Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг уурхайн ажилчдын байр, гал тогоо зэрэгт байрлуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| | | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байх | Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах хогийн цэгийг тохижуулж, ахуйн хог хаягдлыг сумын ЗДТГ-аас зааж өгсөн газарт зайлуулж байсан бөгөөд төлбөрийг төлж барагдуулсан. | Үйл ажиллагааны зардал | |
| 2 | Аюултай хог хаягдал | Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах | Аюултай хог хаягдлыг зориулалтын түр хадгалах цэгт байгуулж зассан. | 800,000.00 | |
| | | Хуванцар сав, шил, лааз, дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, цаасны хаягдал гэх мэт дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой хаягдлуудыг нэг дор цуглуулж хуримтлуулах, боломжтой бол хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах | Уурхайн үйл ажиллагаа 2025 оноос эхэлж бүтээн байгуулалт, тохижилт ажлууд шат дараалалтай явагдсаар байна. | Үйл ажиллагааны зардал | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах | Хөрс шатах тослох материалаар бохирдоогүй байна. | Үйл ажиллагааны зардал |
| | | Хаягдал бохир усыг “Ирвэс Интертрейд” ХХК-ийн худалдаалж буй “Тамир-Эм” био бэлдмэлээр сар тутам ариутгаж бие засах газар луу зайлуулах | Ариутгалын бодисыг шингэн хаягдлын цэг болон гадна ариун цэврийн байгууламжид хийж ариутгаж байна. | Үйл ажиллагааны зардал |
| | | Хэрэглэсэн батарей, принтерийн хор гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах | Хэрэглэсэн батарей, принтерийн хор гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг битүүмжлэл хайрцагт цуглуулж хадгалдаг. | Үйл ажиллагааны зардал |
| **Нийт дүн** | | | | **4,820,000.0** |

## 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

*Хүснэгт 26. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэг байршил | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | | | Хөрсөн бүрхэвч | | |
| 1 | Хөрсний агрохими, хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr)<br>Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо | - Төслийн талбай агрохими, хүнд металл-10 цэг<br>- Хөрсний микробиологийн шинжилгээ-5 цэгт | Хөрсний агрохими, хүнд металл болон хөрсний эрүүл ахуйн дээж тус бүрийг “Грийн лаб” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав). | 50,000.0*12 | 600,000.00 |
| | | | Усны чанар | | |
| 2 | Ерөнхий хими | - Гүний худгийн ус-1 цэг | Уурхайн усны эх үүсвэрээс 1 удаа дээж авч “Грийн лаб” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид болон шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав). | 90,000.0 | 90,000.000 |
| | | | Агаар | | |
| 3 | $NO_2$, $SO_2$<br>Тоос нийт (PM10, PM2.5) | Төслийн талбайд -3 цэг<br>- Уурхайн карьер орчим<br>- Ажилчдын байр<br>- Технологийн зам | Өөрийн зөөврийн багажаар БО мэргэжилтэн хэмжилт хийсэн. | - | - |
| 4 | Дуу шуугиан хэмжээ | Төслийн талбай орчимд-2 цэг | Уурхайн өөрсдийн эзэмшлийн зөөврийн дуу шуугиан хэмжигч багажаар хэмжилт хийж ажиллаж байна. | - | |
| | | | **Нийт дүн** | | **690,000** |

# 11. ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах болович төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

*Хүснэгт 27. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт*

| № | 2025 онд хэрэгжүүлэх БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төлөвлөсөн ажлууд | 2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|
| 1 | Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх | - Нийгмийн хариуцлагын хүрээнд уурхайн ажиллах хүчнийг сум орон нутгаас бүрдүүлж байна. Баянхонгор аймгийн 20 гаруй хүн ажиллаж байна. Нийт ажилчдын 80 гаруй хувь нь юм.<br>- Орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх нөгөөтээгүүр уурхайн ажилчдыг эрүүл хоол хүнсээр хангахаар мал мах худалдан авалтыг малчин өрхүүдээс нийлүүлж байна.<br>Бог- 8 ширхэг<br>Бод- 10 Ширхэг<br>- Жаргалант сумын ашиглалтаас гарч байгаа хуучин хогийн цэгийг түрж нөхөн сэргээж шинэ хогийн цэг байгуулан тохижуулахад 18 хоногийн турш 4 техник 8 хүн ажиллаж 60 орчим сая төгрөг зарцуулсан байна.<br>- Байгаль орчныг хамгаалах, уул уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх чиглэлээр хамтран ажиллах 2025 оны 09-дүгээр сарын 04-ны өдөр №2025/90 тоот гэрээг байгуулж гэрээт үүргээр хүлээсэн мөнгөн зардлыг бүрэн шилжүүлж санд төвлөрүүлсэн./гэрээний үнийн дүн тусгаж болохгүй/<br>- БИНХ-ын тогтоол, тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу ажлуудыг шат дараатай хийж байгаа бөгөөд 2025 оны намар Жаргалант сумын Хөндлөн булаг 3-р багийн амьдралын түвшин болон сургалтын чанараас хамаарч 5 оюутанд 25,000,000 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон. |

| | | |
|---|---|---|
| | | - Хөндлөн булаг 3-р багийн ахмад настай болон хүн хүчний дутагдалтай 8 айл өрхийн өвөлжөөний хөрзөн хуулж зөөж буулгаж өгсөн ба 5 сая төгрөг зарцуулсан.<br>- Жаргалант суманд Хөндлөн булаг 3-р багт чоно сүрэг элбэгшиж айл амьтны эд хөрөнгөд ихээр халдаж хохирол учруулж байгаатай холбогдуулан нутгийн захиргааны байгууллагаас санаачлан зохион байгуулж байгаа чонын ав хөтөлбөрт гарч буй шатахуун түлш, хоол хүнс бусад зардлын мөгийг бүрэн дааж санхүүжүүлсэн ба 7,5 сая төгрөг болсон. |
| 2 | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа). | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажил хийлгэхээр 2025 оны 09-дүгээр сарын 09-ний өдрийн ХББ/25/08 тоот гэрээг Дойтын булаг ХХК-тай байгуулан хийж гүйцэтгүүлж байна. |
| 3 | Эвдэрдсэн талбайн хэмжээг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлэх | Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан. |
| 4 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах | Орон нутгийн менежер сум орон нутагт тогтмол ажиллаж компани болон орон нутгийн хамтын ажиллагаанд анхаарч санал хүсэлтийг ойр давтамжтай авч шийдвэрлэхэд анхаарч ажилласан. |
| 5 | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ –нд хүргэж өгөх. | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨ–нд хүргэж ажиллаж байна. |
| **Нийт дүн** | | **107,500,000** |

## 12. ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

**Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх.** зөвшөөрөлтэй “Бөөргийн ам” нэртэй алтны шороон ордыг ашиглах төслийн төсөл нь Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутагт хэрэгжих тул төслийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хамгийн их сонирхогч, оролцогч талууд нь эдгээр дүүргийн удирдлагууд, ард иргэд, оршин суугчид болно. Тиймээс сонирхогчид болон оролцогч талуудад хүргэх мэдээллийг тэдгээрийн сонирхолд нийцсэн хэлбэрээр бэлтгэж, хэлэлцүүлэх, танилцуулах арга хэмжээг хийх шаардлагатай.

*Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь*

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийг бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|
| 1 | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл хэлбэрээр 2025 оны 11-р сарын 14-ний өдөр хүргүүлсэн. |
| 2 | Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч,<br>Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл хэлбэрээр 2025 оны 11-р сарын 14-ний өдөр хүргүүлсэн. |
| 3 | Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдэд | Төслийн ажилчид болон орон нутгийн иргэдэд танилцуулж санал хүсэлтийг тухай бүр сонсож үйл ажиллагаанд тусгаж байна. |
| **Нийт дүн** | | **-** |

# 13. ДҮГНЭЛТ

Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутагт орших “Жамп ХХК-ийн MV-020399 тоот тусгай зөвшөөрөлтэй “Бөөргийн ам” нэртэй алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаа нь 2025 оны 9-10 дугаар сарын хооронд явагдсан 2025 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2025 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 – ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу боловсруулав;
- “Жамп” ХХК нь 2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт 158,285,000 төгрөг зарцуулсан байна.
- Тус дүнд Байгаль орчныг хамгаалах, уул уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив тусламж өгөх чиглэлээр хамтран ажиллах гэрээний үнийн дүн болон нүүлгэн шилжүүлэх нөхөн олговрын зардал ороогүй болно.